

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, **2024 оны 11 дүгээр сарын 06-ны “Лхагва” гарагт** багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, ТЗУХ-ийн мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД		
1	Улс, нийслэл, дүүргийн төсвийн орлого бүрдүүлэлтэд анхаарч орлогыг нэмэгдүүлэн, эх үүсвэрийн бааз суурийг өргөжүүлэх ажлуудаа эрчимжүүлэн, бүрдүүлэлтийг жигд хангах.	Татварын хэлтэс
2	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд ажилтан, албан хаагчдаа эрүүл мэндийн үзлэгт хамруулж, сэтгэл зүйн оношилгоо хийлгэх.	Нийт байгууллага
3	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, инженерийн шугам сүлжээний хэвийн найдвартай үйл ажиллагааг хангаж ажиллах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, инженерийн дэд бүтцийн байгууллагууд
4	Өвөлжилтийн бэлтгэл ажил, давс, бодисын нөөцлөлт, хот нийтийн аж ахуйн машин тоног, төхөөрөмжийн бэлэн байдал болон хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд анхаарах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, ашиглагч байгууллагууд
5	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд ажилтан, албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах.	Нийт байгууллага
6	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтанд гадаад харилцаа, дипломат ёс, ёслолын дэг журмын талаар сургалтыг зохион байгуулах.	Нийт байгууллага
7	Нийслэлийн хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй үзүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарт хяналт шалгалтыг зохион байгуулах.	ЭМТ
8	Нийслэлийн хэмжээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг анхаарч, өргөдөл, гомдол үүсгэсэн шалтгаан нөхцлийг судалж танилцуулах.	ЗДТГ-нийт байгууллага
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
9	Дүүргийн нутаг дэвсгэрт явган хүний зам шинээр барьж байгуулах шаардлагатай байршлуудын судалгааг гарган холбогдох газарт хүргүүлэх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ
10	Дүүргийн нутаг дэвсгэрт ухаалаг “Хогны сав” байрлуулах шаардлагатай байршлуудыг судалж, төсөв өртгийг танилцуулах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
11	Төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, зураг, төсөв, ажлын даалгаврыг боловсруулах үүднээс дүүрэгт захиалагчийн Ажлын алба байгуулах боломж нөхцөлийг судалж, танилцуулах.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц
12	Хот хооронд нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэхэд анхаарч, холбогдох	ТХҮХ

	арга хэмжээг авч ажиллах.	
13	Хот тохижилтын машиныг татан авах ажлыг шуурхай зохион байгуулж, засвар үйлчилгээ, бэлэн байдлыг хангах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
14	УБ-Чойр чиглэлийн А/0101 авто зам дагуух түүвэр цэвэрлэгээг зохион байгуулах.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
15	Univision төхөөрөмж дүүрэгт нэвтрүүлэх хүсэлтийг судалж, боломж нөхцөл байгаа эсэхийг тодруулах.	ТХҮХ
16	Цас цэвэрлэгээний хуваарийг шинэчлэн батлуулах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Хороод
17	Байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулж, хийж хэрэгжүүлсэн ажлаа олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах.	Нийт байгууллага

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР